

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Борхойн Баянбүрд ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/07/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2025 он</p>	<p>Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Г.Шүрэнцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <p><b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж, 3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103, Утас: (976) 7052 2734 Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn <u>2025.03.14</u> № <u>1-6/301</u> танай _____-ны № _____-т</p>	<p><b>БОРХОЙН БАЯНБҮРД ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА</b></p>
<p><b>Өөрчлөлтгүй дүгнэлт</b></p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Борхойн Баянбүрд ОНӨААТҮГ -ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p><b>Асуудлыг онцолсон хэсэг</b></p> <p>Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.</p> <p>Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.</p> <p><b>Аудитын гол асуудал</b></p> <p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	
<p>442507130</p>	

### **Бусад асуудлын хэсэг**

Борхойн Баянбүрд ОНӨААТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>70,800,615.10</b>	<b>33,527,414.61</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	45,101,170.10	11,477,060.52
1.1.6	Бараа материал	25,699,445.00	22,050,354.09
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>70,800,615.10</b>	<b>33,527,414.61</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,679,643,022.98</b>	<b>1,811,125,958.41</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	331,493,022.98	462,975,958.41
1.2.2	Биет бус хөрөнгө	1,348,150,000.00	1,348,150,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,679,643,022.98</b>	<b>1,811,125,958.41</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,750,443,638.08</b>	<b>1,844,653,373.02</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	<b>46,595,107.78</b>	<b>22,487,308.10</b>
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>46,595,107.78</b>	<b>22,487,308.10</b>
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	46,595,107.78	22,487,308.10
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>46,595,107.78</b>	<b>22,487,308.10</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>1,703,848,530.30</b>	<b>1,822,166,064.92</b>
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.5	- хувийн	1,389,469,766.80	1,389,469,766.80
2.3.8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(558,042.85)
2.3.9	Хуримтлагдсан (алдагдал)	314,378,763.50	433,254,340.97
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,703,848,530.30</b>	<b>1,822,166,064.92</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,750,443,638.08</b>	<b>1,844,653,373.02</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	703,361,138.02	670,808,035.27
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг</b>	<b>703,361,138.02</b>	<b>670,808,035.27</b>
4	Ерөнхий ба удирдлагын зардал	389,707,737.14	533,011,063.94
5	Бусад зардал		5,712,996.36
<b>6</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>313,653,400.88</b>	<b>132,083,974.97</b>
7	Орлогын татварын зардал	31,365,340.09	13,208,397.50
<b>8</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>282,288,060.79</b>	<b>118,875,577.47</b>
<b>9</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>282,288,060.79</b>	<b>118,875,577.47</b>
10	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>11</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
12	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Дорноговь аймгийн Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,389,469,766.80</b>	-	<b>314,378,763.50</b>	<b>1,703,848,530.30</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(558,042.85)	<b>(558,042.85)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,389,469,766.80</b>	-	<b>313,820,720.65</b>	<b>1,703,290,487.45</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	118,875,577.47	<b>118,875,577.47</b>
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,389,469,766.80</b>	-	<b>432,696,298.12</b>	<b>1,822,166,064.92</b>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>487,979,578.40</b>	<b>614,535,623.80</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	446,129,078.40	608,374,123.80
	Татаас, санхүүжилтийн орлого	41850500	-
	Бусад мөнгөн орлого	-	6,161,500.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>364,382,727.30</b>	<b>560,116,133.38</b>
	Ажиллагчдад төлсөн	173,685,727.00	284,762,077.00
	Ашиглалтын зардалд төлсөн	832,483.21	2,718,264.81
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,084,334.93	28,025,604.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	148,364,025.02	
	Татварын байгууллагад төлсөн	37,416,157.14	123,490,893.14
	Бусад мөнгөн зарлага		121,119,294.43
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>123,596,851.10</b>	<b>54,419,490.42</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>0.00</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>89,548,281.00</b>	<b>87,327,600.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	89,548,281.00	74,827,600.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		12,500,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-89,548,281.00</b>	<b>-87,327,600.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>9,800,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	9,800,000.00
	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>10,516,000.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		10,516,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>-716,000.00</b>
4.1	Валютын ханшийн зөрүү	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	34,048,570.10	-33,624,109.58
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>11,052,600.00</b>	<b>45,101,170.10</b>
<b>5.2</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>45,101,170.10</b>	<b>11,477,060.52</b>

Дорноговь аймгийн Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	2	3	4	5
1	<b>Нийт борлуулалтын орлого</b>	746,260,600.0	670,808,035.3	75,452,564.7
2	Орон нутгийн санхүүжилт	705,260,600.0	553,067,385.3	152,193,214.7
3	Модны орлого	41,000,000.0	6,161,500.0	34,838,500.0
4	Бусад хандивын орлого		111,579,150.0	(111,579,150.0)
4	<b>Нийт зардал</b>	746,260,600.0	538,728,060.3	207,532,539.7
5	Цалин, урамшуулалын зардал	527,609,500.0	347,540,515.0	180,068,985.0
6	Хөрөнгө оруулалтын зардал	41,000,000.0	23,027,692.7	17,972,307.3
7	Хангамж бараа материалын зардал	47,700,000.0	47,495,400.0	204,600.0
8	Эд хогшил урсгал засварын зардал	20,000,000.0	20,618,000.0	(618,000.0)
9	Томилолт зочны зардал	3,000,000.0	3,030,000.0	(30,000.0)
10	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	28,000,000.0	26,928,300.0	1,067,700.0
11	Бараа үйлчилгээний бусад зардал	13,000,000.0	13,000,000.0	-
15	Татвар, хураамж, шимтгэл	65,951,100.0	57,084,152.6	8,866,947.4
13	Татварын өмнөх ашиг	-	132,083,975.0	
14	ОАТ		13,208,397.5	
14	Цэвэр ашиг/алдагдал/		118,875,577.5	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 491,977.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 90.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 491,887.2 мянган төгрөгт 2 зөвлөмж өгч ажилласан.

#### 3.1 Төлбөрийн акт

##### Илрүүлэлт:

Тайлант онд Замын Үүд сум үүсгэн байгуулагдсантай холбоотой ажилчдад олгох урамшууллын тушаал гаргахдаа захирал өөрийн нэрийг оруулж 90.0 мянган төгрөгийн урамшуулал авсан.

#### 3.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Илрүүлэлт:

Тайлант онд кассын тайлангаар 200.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

##### Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтыг хэрэгжүүлж ажиллах

##### Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуульд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, тогтмол мэдээлэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй 491,687.2 мянган төгрөгийн санхүүжилтийг мэдээллийг байршуулаагүй алдаа гарсан байна.

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд кассын тайлангаар 200.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.	1	200.0					1	200.0				
Тайлант онд Замын Үүд сум үүсгэн байгуулагдсантай холбоотой ажилчдад олгох урамшууллын тушаал гаргахдаа өөрийн нэрийг оруулж 90.0 мянган төгрөгийг авсан байна.	1	90.0	1	90.0								
<b>Нийт</b>	<b>2</b>	<b>290.0</b>	<b>1</b>	<b>90.0</b>			<b>1</b>	<b>200.0</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Мэдээлэл байршуулаагүй	1	491,687.2	-	-	-	-	-	-	1	491,687.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>491,687.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>491,687.2</b>